



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 469

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох  
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 255,565,425.00 (хоёр зуун тавин таван сая таван зуун жаран таван мянга дөрвөн зуун хорин таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгө (угаалга, ариутгалын барилга)-ийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Барилгын доорх газар эзэмших эрхийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн нэр дээр баталгаажуулах, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006000  
24-r huraldaan.docx